



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН**  
**ХОРООНЫ ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

## ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

*2023 оны 6 дугаар сарын 13-ны өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-6

---

- 1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/* 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 6 дугаар сарын 13-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 23 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Сэргэлэн.*

**Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хургүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, “И-Монголиа академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, Сангийн яамны Төсвийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Н.Уранцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт П.Болорцэцэг нар байлцав.

Хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 16 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 39 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Э.БАТШУГАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

*2023 оны 6 дугаар сарын 13-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим  
13 цаг 23 минут*

### **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Э.Батшугар:** Байнгын хорооны эрхэм гишүүд Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 54.5 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь хуралдаанд хүрэлцэн ирсэн дарааллыг танилцуулъя.

Э.Батшугар 28 дугаар тойрог, Т.Доржханд 29 дүгээр тойрог, Ц.Идэрбат 18 дугаар тойрог, Б.Саранчимэг 22 дугаар тойрог, Н.Учрал 28 дугаар тойрог, Ж.Чинбүрэн 23 дугаар тойрог.

Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

орлуулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Засгийн газарт чиглэл өгөх тухай 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сонсох.

Энэ байсан. Гэхдээ өнөөдөр төсөв хэлэлцэж байгаа болохоор дараагийн долоо хоног хүртэл хойшлууллаа.

Хэлэлцэх асуудалд саналтай гишүүд байна уу? Алга.

Шууд асуудалдаа орьё. Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батаагийн Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жамъянгаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Пүрэвжавын Батбаатар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга, Бавуужавын Мягмарнаран “И-Монголиа академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал, Мөнхдоржийн Баттулга “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал, Ням-Осорын Уранцэцэг

Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн танилцуулгыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайд Ням-Осорын Учрал танилцуулна.

Н.Учрал сайдын микрофоныг нээе.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаадын валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өсөж гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 дугаар сарын байдлаар 3.8 тэрбум ам.долларт хүрч сайжраад байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлт гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого, амьжиргааг дэмжих зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулж Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөл дуусгалаа. Тухайлбал,

Нэг.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд

олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох;

Хоёр.Тэтгэврийн зөрүүний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулж нэмэх;

Гурав.Төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж, суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх;

Дөрөв.Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын сүлжээг өргөтгөх зэрэг нийслэлийн түгжрэлийг бууруулах арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1.6 их наяд төгрөг буюу анх батлагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

**Э.Батшугар:** Н.Учрал сайддаа баярлалаа.

Одоо Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтээр Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг танилцуулна.

1 номерын микрофоныг нээе.

**Ц.Наранчимэг:** Байнгын хороон дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781.9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589.5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувьтай байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлтийг оруулсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсөв 2023 оны батлагдсан

төсвөөс 416.6 тэрбум төгрөг, Цахим хөгжил харилцаа холбооны сайдын төсөв батлагдсан төсвөөс 4.5 тэрбум төгрөг буюу төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын нийт төсөв 421.1 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн албан хаагчдын цалин хөлсийг тэнцэн тогтоосон, ажил олгогчдоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдэж байгаа нь голлон нөлөөлсөн байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна гэж дүгнэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Э.Батшугар:** Баярлалаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнээс хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчаас асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй. Алга байна.

Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Монгол Улсын 2023 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Төсвийн байнгын хороонд танилцуулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа.

*Хуралдаан 16 минут үргэлжилж, 13 цаг 39 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**